# НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
# 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| *Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1: Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулж, нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана. НЗДҮАХ 3.5, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, хотын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангана. НХТ 3.5* | | | | | | | |
| Зорилго 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүс нутгийн онцлогт тохирсон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 1.1 Шинэ хоршоо-Чинээлэг малчин арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг сайжруулна. | | | | | | | |
| 1.1.1 | Шинэ хоршоо-Чинээлэг малчин арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд иргэдийг сургалт, мэдээ мэдээллээр хангаж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ. | - | Хоршооны тоо | 36 | 12 | Шинэ хоршоо байгуулах, хоршооны гишүүн малчны зээлд хамрагдах, хоршиж хамтарч ажиллах санал санаачилгыг дэмжин малчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна. Энэ онд Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд 4 удаагийн сургалтаар 344 малчин, фермерт зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. | 100 |
| Зорилт1.2.Малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлж, бүртгэн, тогтвортой ашиглаж, хамгаалах, малын нөхөн үйлдвэрлэл, үржил, селекцийг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, малын генетик нөөцийн төлөвт тохирсон бүс нутгийн үржүүлгийн арга технологийг нэвтрүүлнэ. | | | | | | | |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1.2.1 | Малын бүртгэл мэдээллийн тогтолцоог | нийслэлийн төсөв | Шинээр цахим системд хамрагдсан мал, амьтан мян.тоо | 427.0 | 412.8 | Малын бүртгэл мэдээллийг 2024 оны жилийн эцсийн мал тооллогын дүнтэй уялдуулан шинэчлэх ажлыг дүүргийн мэргэжилтнүүдтэй хамтран хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд 5539 өрхийн 403917 толгой малын тооны шинэчлэлийг хийж, шинээр малтай болсон, шилжиж ирсэн 171 өрхийг, малын хамт шинээр бүртгэж ажиллалаа. 2025 оны 03 дугаар сарын 13-наас эхлэн мал төллөлт, төл бойжилтын мэдээ, малын хорогдлын мэдээг 7 хоног бүр малын бүртгэлийн программд дүүрэг, нийслэлийн дүнгээр оруулж мэдээлэх ажлыг хийж байна.<br><br>2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Мал төллөлт 58.2 хувьтай, гарсан төлийн 99.7 хувь нь бойжиж байна. Том малын зүй бус хорогдол 872 толгой буюу оны эхний малын 0.2 хувь хорогдсон байна.<br>Малын нэгдсэн сангийн бүртгэлийн системд эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн бүртгэл, судалгааг шинэчилж 30 аж ахуйн нэгж, 476 фермер эрхлэгч өрх бүртгэгдсэн.<br>Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн шинэчлэлийн үр дүнд мал бүхий иргэн, АА нэгжийн мэдээлэл E-mongolia цахим системд орж, лавлагаа, мэдээллийг цахимаар авч төрийн үйлчилгээг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх боломжтой болсон. | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1.2.2 | Зөвшөөрсөн бүс дэх хээлтэгч, хээлтүүлэгч малыг генетик нөөцийн үзлэг ангилалтад хамруулна. | Орон нутгийн төсөв 4.5 | Генетик нөөцийн үзлэг, ангилалтад хамруулсан малын тоо | 250 | 250 | Баянзүрх, Хан-Уул дүүргийн сүүний үхэрт үзлэг, ангилалт, бүртгэлжүүлэлт хийхээр төлөвлөж тооцоо, судалгаа гаргасан ч Хан-Уул дүүрэг хөрөнгө санхүүгийн эх үүсвэргүйгээс уг ажил хийгдээгүй хүлээгдэж байна. Баянзүрх дүүрэгт "Жижиг зээрд" Мал эмнэлэг, үржлийн албатай хамтарч 500 үхэрт үзлэг, ангилалт, ээмэгжүүлэлт хийгээд байна. | 100 |
| 1.2.3 | Сүү, сүү-махны, махны үхрийн үүлдэрлэг байдал, сүрэг сэлбэх өсвөр үхрийг удам гарваль, ашиг шимийн чиглэлээр бүртгэлжүүлнэ. | Улс, нийслэлийн төсөв | Сүү, сүү-махны , махны үүлдрийн үнээ, тоо толгой | - | 3000 | Сүү, сүү-махны чиглэлийн үхэр үржүүлэгч 78 иргэний сүүний 850 толгой, сүү-махны хосолмол ашиг шимт үхрийн 700 толгой өсвөр үхрийн судалгаа гаргаж, бүртгэлжүүлэлт хийгдсэн байна. | 50 |
| 1.2.4 | Эрчимжсэн сүүний үхрийн аж ахуйд үржүүлж буй цэвэр үүлдрийн (хар тарлан) үхрийн тоог нэмэгдүүлнэ. (НХТ 266) | Нийслэлийн төсөв | Зохиомол хээлтүүлэгт хамрагдсан хээлтэгчийн тоо | 312 | 500 | Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдэд мал үржлийн 3 нэгжийн 5 техникч захиалгын дагуу дэлхийн бух үнэлгээний газраар баталгаажсан хээлтүүлэгч малын гүн хөлдөөсөн үрээр 890 үнээнд хээлтүүлэг хийхээр төлөвлөн ажиллаж байгаагаас 380 толгой хээлтэгчийг хээлтүүлэгт хамруулсан. | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1.2.5 | Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг ашиг шимийн чиглэлээр төрөлжүүлэн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (НЗДҮАХ 3.5.4) | Нийслэлийн төсөв | Шинээр байгуулагдсан кластерын тоо | - | 1 | Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны 3 хоршоо, фермерүүдэд эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийн ашиг шимийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх талаар танилцуулга хийж, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын тэжээлийн тариалан эрхлэгчид фермерүүдтэй уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 7 аж ахуй нэгжийн төлөөлөл хамрагдсан ба кластер хэлбэрээр хөгжүүлэх Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны 3 хоршоо,<br>фермерүүдэд эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийн ашиг шимийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх талаар танилцуулга хийж, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын тэжээлийн тариалан эрхлэгчид фермерүүдтэй уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 7 аж ахуй нэгжийн төлөөлөл хамрагдсан ба кластер хэлбэрээр хөгжүүлэх сонирхолтой иргэн, хоршоо байгаа ч одоогийн ашиглаж буй газар нь боломжгүй тул хороо дүүрэгт кластер бий болгох газар байхгүй, мөн энэ чиглэлээр хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутмаг байна. | 70 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Зорилт 1.3. Мал амьтныг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, усалгаа, өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлнэ. (НХТ-276) | | | | | | | |
| 1.3.1 | Мал амьтныг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, усалгаа, өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлнэ. | Орон нутгийн төсөв | Аюулгүй нөөцөд бэлтгэсэн өвсний хэмжээ. тонн | 280 | 280 | Засгийн газрын 2024 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоолоор нийслэлийн аюулгүйн нөөцөд 100тн өвс, 30тн тэжээл бэлтгэх үүргийг өгсөн бөгөөд тухайн ажлыг 2025 оны III улирлаас эхлүүлэн хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Мөн Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1366 тоот захирамжаар өвөлжилт, хаваржилт хүндэрч зудын нөхцөл байдал үүссэн үед Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 80,8 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлүүлсэн бөгөөд тухайн онд цас, зудгүй байсан тул тус хөрөнгийг зарцуулаагүй болно. | Хугацаа болоогүй |
| | | | Аюулгүй нөөцөд бэлтгэсэн тэжээлийн хэмжээ. тонн | 210 | 210 | | |
| 1.3.2 | Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах Нийслэлийн засаг даргын захирамж, | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 95 | 100 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны “Мал аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын ажлыг эрчимжүүлэх тухай” 02 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | байна.<br>Энэ хүрээнд Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын А/1057 дугаар захирамж, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын А/28 дугаар тушаалаар Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын 6 бүлэг 22 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Энэ жил цас, зуд багатай байсан тул мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт тавтай байлаа.<br>Нийслэлийн хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн зарцуулалтын мэдээг гарган ажиллаж байна. | |
| Зорилго 2. Хөдөө аж ахуйн механикжуулалтын түвшинг сайжруулан, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлж, хадгалалтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 2.1. Хөдөө аж ахуйн эдэлбэр газар ашиглалтыг сайжруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 2.1.2 | Байгууллагын эзэмшил газрын ашиглалтыг сайжруулж, | Төр, хувийн хэвшлийн | Гэрээ байгуулж, дүгнэсэн тоогоор | 3 | 8 | Хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зориулалтын дагуу газраа ашиглаагүй үндэслэлээр Газрын даргын 2024 оны А/30 дугаар тушаалаар байгуулагдсан Байгууллагын газар ашиглалтыг сайжруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн шийдвэрийг удирдлагуудад танилцуулан нэр бүхий 2 аж ахуйн | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | эргэлтэд оруулна. | түншлэл,олон улсын төсөл хөтөлбөр | | | | нэгжид гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлсэн.<br>Мөн байгууллагын эзэмшилд байсан БЗД-ийн 11 дүгээр хороо Хонхор дах 9.6 га газрыг төлбөрийн болон бусад баримт бичгийн бүрдлийг хийн хасалт хийлгэж, ХХААХҮСХТ-д нэр шилжүүлсэн тухай НЗД-ын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/696 дугаар захирамж гарсан.<br>Хамтран ажиллах гэрээний хүрээнд 1, байгууллагаас төлбөр гүйцэтгэдэг 6 нэгж талбарын 2025 оны төлбөрийн нэхэмжлэхийг дүүрэг, нийслэлийн ГЗБА-тай тооцоо нийлж байгууллагын Ерөнхий нягтлан бодогчид өгсөн. | |
| 2.1.3 | Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | Төр, хувийн хэвшлийн түншлэл, олон улсын төсөл хөтөлбөр 200.0 | Хураан авсан таримлын хэмжээ, тн | 13240 | 13500 | Азиа Монголия ТББ, Италийн хөрөнгө оруулалттай “Хүнс тэжээлийн дутагдлын эсрэг хүнсний аюулгүй байдал”-ыг нэмэгдүүлэхэд тариаланчдыг дэмжих төсөлд Сонгинохайрхан дүүргийн 3 гудамж, Баянзүрх дүүргийн 2 гудамжны 75 өрх хамрагдаж 08 га талбайд төмс, хүнсний ногоо тариалахаар худаг ус гаргах, хүлэмж барих ажлыг төлөвлөн ажиллаж байна. Ил талбайд тариалах төмс 10000кг урт сонгино 18 кг үр олгогдож нийслэлийн 3 дүүргийн 20 гаруй иргэдэд олгож 7 га талбайд тариалууллаа. ХХААХҮЯамнаас хүлэмжид тариалах өргөст хэмх 423 уут, улаан лооль 13 уут, | 70 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | чинжүү 5 кг үрийг 6 дүүргийн тариаланчдад 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож, 14,2 га талбайд тариалалт хийгдэж байна. | |
| Зорилт 2.2. Агросити хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тогтвортой хөгжлийг хангаж, өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 2.2.1 | ”Агросити” 45,000 тонн хүнсний нарийн ногоо хураах, хүлэмжийн аж ахуйн кластер бүхий эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг эхлүүлэхэд холбогдох байгууллагатай хамтарч ажиллана. (НЗДҮАХ 3.5.2) | Төр, хувийн хэвшлийн түншлэл, олон улсын төсөл хөтөлбөр | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 0 | 100 | 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ХХААХҮЯамны Судалгаа хөгжлийн төв, Агросити тусгай бүсийн захиргаа, Хот байгуулалт, хотын стандартын газрын Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн Газар зохион байгуулалтын албаны төлөөлөлтэй тусгай бүс байгуулах төлөвлөлтийн байршил газар дээр очиж, анхны уулзалтыг хийсэн.<br>2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын “Агросити” дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах нээлттэй тендер /дугаар НХААГ/20250103049/ зарлагдсан.<br>Хот байгуулалт, хотын стандартын газрын Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтсийн Төлөвлөлт судалгаа хариуцсан ажилтан Г.Ичинхорлоод /88314142/ 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Агросити тусгай бүсийн мэдээллийг хүргэн ажилласан.<br>Тусгай бүсийн захирагчид хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн судалгааг 2025 оны 05 дугаар сарын | 70 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | 09-ны өдрийн А/357 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| Зорилт 2.3 Төмс, хүнсний ногооны зоорь, агуулахын багтаамжийг нэмэгдүүлэхээр хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, хүнсний стандартын шаардлага хангасан тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 2.3.1 | Хүнс, нарийн ногоо, жимс, махан бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалалт, борлуулалтын цогцолбор төвүүдэд нийт 50,000 тонн багтаамжтай агуулах байгуулах жимсгэнэ, мах, бэлтгэл ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдэж, | Төр, хувийн хэвшлийн түншлэл, олон улсын төсөл хөтөлбөр | Ашиглалтад орсон агуулахын багтаамж, тн | 89158 | 94158 | Малын зах, мах боловсруулах үйлдвэрийн цогцолбор төвийг хотын зүүн, баруун бүсэд байгуулах бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд "МБҮ Трейд" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, баруун хойд талд 15.0га, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Оргил худалдааны төвийн хойд талд 6.26га газрын асуудлыг шийдвэрлэн ТЭЗҮ болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчны үнэлгээ, ажлын зураг төсөл хийгдсэн.<br>2025 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн Хүнс үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан зөвлөх О.Оргилд бүтээн байгуулалтын үйл ажиллагааны талаар Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо Эмээлт төвийн газар | 70 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | иргэдийг эрүүл, баталгаат хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ. (НЗДҮАХ 3.5.3) | | | | | дээр очиж танилцуулга хийсэн. УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлийн үр дүнд Сонгинохайрхан дүүргийн 21 хороонд Фамили фүүдс трейт ХХК-ний 1000тн, иргэний 160 тн багтаамжтай агуулах нэмэгдсэн байна. | |
| Зорилго 3. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний улирлын хамаарлыг бууруулж, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 3.1 Түүхий эдийн нөөц ашиглалтыг сайжруулж, үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 3.1.1 | Нийслэлийн хүн амын хүнсний хангамжийн бүрдүүлэлт, нийлүүлэлтийн тооцоо судалгаа хийх, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийн тасалдалгүй байдлыг ханган ажиллана. | 80.0 | Хангамжийн түвшин, хувь | 41.5 | 45.0 | Нийслэлийн хүн амын гол нэрийн хүнсний хангамжийн тооцооллыг хийж, холбогдох илтгэл, танилцуулгыг бэлтгэж, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус тогтоолын хүрээнд зохион байгуулагддаг төрийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалтад нийслэлийн хүнсний хангамжийг сайжруулахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжуудын талаарх бодлогыг боловсруулж, танилцуулахаар бэлтгэл хангаад байна. 5 дугаар сард төлөвлөгдсөн байсан тус уулзалт тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. Нийслэлийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тасалдалгүй байдлыг хангах зорилгоор гол нэрийн хүнсний томоохон 100 аж ахуйн нэгжээс бодит нөөцийн мэдээг авч, хангамжийн тооцоог хийн, холбогдох байгууллагад 7 хоног бүр хүргүүлэн ажиллаж байна.<br>2025 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 10.6(9.6%) тэрбум | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | төгрөгөөр, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл 19.9(17.9%) тэрбум төгрөгөөр, нарийн боовны үйлдвэрлэл 10.3% тус тус өссөн байна. Мөн 989076.2 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оны мөн үеэс 5.3%-ийн өсөлттэй байна.<br>Хүнсний боловсруулсан бүтээгдэхүүний хангамж 2025 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 70.1 хувь байна. | |
| 3.1.2 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан түр журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын хүрээнд 2218 фермер эрхлэгч 6.3 сая литр сүүг бэлтгэн нийлүүлж, 6.3 тэрбум төгрөгийн урамшуулал авсан. Ингэснээр өвлийн улиралд нийлүүлэх сүүний хэмжээ нэмэгдэж, улмаар үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ 2025 оны 03 дугаар сарын байдлаар 4.99 сая литр байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 404.8 мян.л-ээр буюу 8.1%-иар өссөн дүнтэй байна. | 100 |
| Зорилт 3.2. Мах, махан бүтээгдэхүүний техникийн зохицуулалтыг хэрэгжүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1 | Нийтийн хэрэгцээнд нийлүүлэх үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг нэмэгдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | - | Нийт маханд эзлэх хувь | 6.2 | 8 | МУ-ын Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоол “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ын 3.14.9, 5.2.1-д заасан шаардлагыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор нийслэл, 21 аймагт үйл ажиллагаа явуулж байгаа “Мал төхөөрөх, боловсруулах” 216 аж ахуйн нэгжээс авсан судалгаа, танилцуулгыг УБЗАА-д хүргүүлсэн.<br>УБЗАА, НХХААГ, НМЭГ, НОБГ, 9 дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран мал төхөөрөх, боловсруулах үйлдвэр, ресторан, томоохон зах худалдааны төвийн бэлэн байдлыг хангуулах ажлыг зохион байгуулсан.<br>Мөн нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан мах экспортлогч 13 аж ахуйн нэгжийн үйлдвэрийн аргаар бэлтгэж, нөөцөлсөн үхэр, хонины махны өргөтгөсөн худалдааг ХХААХҮЯ, УБЗАА, НХХААГ-тай хамтран 2025 оны 02 дугаар сарын 05-аас 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан.<br>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны А/08 дугаар тушаалын хүрээнд Хүн амын стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар УБЗАА, НХХААГ, НЭМГ, НМЭГ, НОБГ, дүүргүүдийн ХХҮХ-тэй хамтран нийслэл хотод байрлалтай бэлтгэн нийлүүлэгч 7 аж ахуйн нэгж, хөдөө орон нутгаас оролцож байгаа 3 аж ахуйн нэгжид хяналт, шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан.<br>Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ 2024 оны 04 дүгээр сарын байдлаар 7.1 мян.тн, 2025 оны 04 дүгээр сарын байдлаар 8.5 мян.тн буюу өмнөх оны үеийнхтэй харьцуулахад 10.3 хувиар өссөн дүнтэй байна. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 3.2.2 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолыг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | - | Аж ахуйн нэгжийн тоо | - | 10 | 2025 оны 05 дугаар сард зохион байгуулагдсан үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад хамрагдсан махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг 15 аж ахуйн нэгжид Мах, махан бүтээгдэхүүний техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгсөн.<br>Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт хийх сургалтыг 3 дугаар улиралд холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 30 |
| Зорилт 3.3 Стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | | | | | | | |
| 3.3.1 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмын дагуу шаардлагатай тооцоо, судалгааг гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 5.0 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх журмын дагуу нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд шаардлагатай мах, усны нөөцийн тооцоололыг гарган 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 122 дугаартай албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.<br>Нийслэлийн хүн амын 2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтыг 3 удаа зарлаж, шаардлага хангасан 6 аж ахуйн нэгж 3480 тн мах, мөн өөрийн хөрөнгөөр мах бэлтгэсэн 4 аж ахуйн нэгжийн 4900 тн мах, нийт 8380 тн мах бэлтгэн нөөцөлсөн. 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 9 дүүргийн хэмжээнд 446 цэгээр, мөн өргөтгөсөн худалдааг 40 байршилд зохион | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | байгуулагдаж байна.<br>2026 оны хаврын улирлын хэрэгцээнд нийлүүлэх мах бэлтгэлийн ажил 2025 оны 08 сараас эхлэнэ. | |
| 3.3.2 | Нийслэлийн “Хүнсээр хангах алба”-ны холбогдох чиг үүргийг хэрэгжүүлнэ. | 1.5 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | 2024 оны нийслэлийн хүн амын тоонд үндэслэн Улаанбаатар хотын жишсэн хүн амын тоог тооцоолон бодож, гамшгийн үеийн 3 хоногийн хүнсний хэрэгцээ, гамшгийн үед ажиллах аврагчид, нэрвэгдэгсэдийг хоол, хүнсээр хангахад шаардагдах гол нэрийн бараа бүтээгдэхүүний хэрэгцээний тооцооллыг ҮСХ-ны даргын 2023 оны А/165 тоот тушаалаар батлагдсан “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал батлах тухай”, ЭМС-ын 2017 оны А/74 тоот тушаалын хавсралт тус бүрийг үндэслэн тооцож гаргасан.<br>Хүнсээр хангах албанд долоо хоног бүр 100 хүнсний боловсруулах үйлдвэр, импортын хүнсний бүтээгдэхүүний 64 аж ахуйн нэгжээс нөөцийн мэдээг авч нэгтгэн, заасан хугацаанд хүргүүлдэг.<br>Болзошгүй гамшгийн үед хүнс нийлүүлэх 56 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг 3 дугаар улиралд шинэчлэхээр төлөвлөсөн. | 100 |
| Зорилго 4. Хөдөө, аж ахуйн салбарын үйл ажиллагааг дэмжиж, бизнес үйлчилгээ эрхлэхэд таатай орон зайг бий болгоно. | | | | | | | |
| Зорилт 4.1 Бүх нийтийн боловсролыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж урамшуулах замаар салбарын үйл ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | |
| 4.1.1 | Улс, нийслэлийн хэмжээнд хөдөө аж | Нийслэлийн төсөв | Салбарын аваргуудын тоо | 9 | 9 | Монгол улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Улсын аварга фермерээр Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | ахуйн салбарын шилдгүүдийг шалгаруулах ажлыг зохион байгуулна. | | | | | дүгээр хорооны фермер Должингийн Гантөр, Улсын аварга тариаланч хамт олон "Баянбүрд ногоон төгөл" ХХК Улсын аварга малчнаар Багануур дүүргийн 1 дүгээр хорооны малчин Даржаагийн Нармандах, Юрагийн Батбаатар нар шалгарав.<br>Нийслэлийн ЗД-ын 2024 оны А/68 дугаар Захирамжаар "Нийслэлийн аварга фермер шалгаруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулж, 2025 онд "Нийслэлийн аварга фермер"-ээр Багануур дүүргийн 4 дүгээр хорооны фермер Д.Наранбаатар, Налайх дүүргийн 3 дугаар хорооны фермер Т.Батсугар, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны фермер Ш.Батпүрэв, Д.Бямбасүрэн нарын нийт 4 хүнийг шалгаруулан Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, НХХААГ-ын дарга Х.Эрдэнэбилэг нар шагналыг гардуулж өгсөн. | |
| 4.1.2 | Хүнсний зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх зорилтот арга хэмжээг зохион байгуулна. | 9.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 2 | 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр "Дэлхийн сүүний өдөр"-ийг уламжлал болгон 9 дэх жилдээ "Милк фестиваль-2025" нэрийн дор анх удаа өргөн хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа. "Дэлхийн сүүний өдөр" нь Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөртэй давхцан тэмдэглэдэг тул тус арга хэмжээгээр хүүхэд багачуудад сүү, сүүн бүтээгдэхүүний дээжийг бэлэглэх, хүүхдүүдэд зориулсан соёл урлагийн тоглолт, төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулж, сүү, сүүн бүтээгдэхүүний амталгаа, худалдаа | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | бүхий цогц арга хэмжээг зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүллээ. Дэлхийн сүүний өдрийн арга хэмжээний хүрээнд “Хүүхдийн сүүний хэрэглээг нэмэгдүүлэх боломж” сэдэвт форум хэлэлцүүлэг хийгдэж, 2025.05.30-нд Монголын Үндэсний телевизээр цацагдсан. Жил бүрийн III дугаар улиралд уламжлал болгон зохион байгуулагддаг “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээнд хүнсний боловсруулах үйлдвэрүүдийг хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана | |
| 4.1.3 | Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг идэвхжүүлэх, салбарын шилдэг ажилтныг шалгаруулж, урамшуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна. | 1.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | Жил бүр “Бялуу чимэглэх улсын уралдаан”-ыг Монголын Хүнсний холбоотой хамтран зохион байгуулдаг. Энэ жил Монголын Хүнсний холбооны дотоод үйл ажиллагаанаас хамааран IV улиралд хийхээр хойшлогдсон. | - |
| Зорилт 4.2 Үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | | | | | | | |
| 4.2.1 | Хүнсний боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдэд | 6.0 | Үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн | 50 | 65 | Чанарын менежментийн тогтолцооны угтвар нөхцөл болох үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийн мэргэжил, арга зүйн | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | холбогдох сургалт, сурталчилгааг зохион байгуулна. | | нэгжийн тоо | | | зөвлөгөө өгөх сургалтыг жижиг, дунд хүнсний боловсруулах үйлдвэр эрхлэгч 75 аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор 89 технологич, ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. Үүнд:<br>- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 19,<br>- Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 14,<br>- Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 32,<br>- Ундаа, жүүс үйлдвэрлэлийн 10 аж ахуйн нэгж оролцсон.<br>Сургалтын үеэр Технологийн дээд сургуулийн хоол үйлдвэрлэл, талх, нарийн боов үйлдвэрлэлийн дадлагын газар, итгэмжлэгдсэн болон сорилтын лабортаориуд, үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал, HACCP тогтолцоог нэвтрүүлэн үйл ажиллагаагаа явуулж буй тус сургуулийн мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай нийт оролцогчдыг танилцуулав. Тус танилцуулах үйл ажиллагаа нь сургалтаар олгосон мэдлэгийг бататгах оновчтой сонголт байсан бөгөөд үүнийг нийт оролцогчид санал асуулгаар болон биечлэн талархал илэрхийлсэн. Сургалтын төгсгөлд нийт оролцогчдоос QR кодоор санал асуулга авсан. | |
| 4.2.2 | Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл | - | Үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн | 28 | 30 | УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд "Хүнсний хангамж аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг нийслэлд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | ажиллагаа эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | | нэгжийн тоо | | | тусгагдсаны дагуу банкны эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй аж ахуйн нэгжүүдэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Үүнд: мах, махан бүтээгдэхүүний 4, сүү, сүүн бүтээгдэхүүний 1, гурил, гурилан бүтээгдэхүүний 1, уламжлалт технологиор үйлдвэрлэх согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл хүссэн 1 аж ахуйн нэгж байна.<br>Мөн нийслэлд согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлдэг 19 аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн захиалгыг хүлээн авч нэгтгэн, мөн спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалтын 2024 оны тайлангийн хамт Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | |
| Зорилт 4.3. Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | | |
| 4.3.1 | "Алтан намар", "Намрын ногоон өдрүүд" арга хэмжээний хүрээнд эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногооны өргөтгөсөн | Нийслэлийн төсөв | Төмс, хүнсний ногооны борлуулалт. тонн | 10,000 | 10,000 | Намрын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлыг III-р улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | Хугацаа болоогүй |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | худалдааг зохион байгуулна. | | | | | | |
| 4.3.2 | Хөдөө аж ахуйн салбарын нэгдсэн арга хэмжээнд нийслэлийн аж ахуйн нэгжүүдийн оролцоог хангахад дэмжлэг үзүүлнэ. | - | Оролцсон аж ахуйн нэгжийн тоо | 40 | 65 | Хүнс, хөдөө аж ахуйн салбарын "Намрын ногоон өдрүүд-2025" нэгдсэн арга хэмжээ 3 дугаар улиралд зохион байгуулагдана. | Хугацаа болоогүй |
| Зорилго 5. Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангана. | | | | | | | |
| Зорилт 5.1 Нийслэлийн хүн амын Хүнсний сүлжээний бүх үе шатуудад хүнсний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлийг бууруулах хяналт шалгалтыг зохион байгуулах, зөрчлийг арилгуулна. | | | | | | | |
| 5.1.1 | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ. | - | шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь | 77,6 | 80 | Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлын салбарын эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 600 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар 60 хувь буюу 362 объектыг хамруулан 777 зөрчил илрүүлснээс 321 буюу 41.3 хувийг арилгуулж ажилласан. Салбараар нь:<br>1.Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн 85 объектоос 37 объектод хяналт шалгалт хийж 79 зөрчил илрүүлснээс 14 буюу 17 хувийг арилгуулсан.<br>2.Нийтийн хоолны чиглэлийн 170 объектоос 85 объектод хяналт шалгалт хийж 229 зөрчил илрүүлснээс 59 буюу 25 хувийг арилгуулсан.<br>3.Худалдааны чиглэлийн нийт 270 объектоос 204 газар | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | буюу 73 хувь нь хамрагдаж 376 зөрчил илрүүлснээс 187 буюу 49 хувийг арилгуулсан.<br>4.Ургамал хамгааллын чиглэлийн 75 объектоос 36 объектод хяналт шалгалт хийж 93 зөрчил илрүүлснээс 61 буюу 66 хувийг арилгуулж илрүүлснээс 374 буюу 55,8 хувийг арилгуулсан.<br>Худалдаа, хоол үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл, ургамал хамгааллын чиглэлээр нийт 223 иргэн, аж ахуйн нэгжид албан шаардлага, 157 албан даалгавар хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж 174 иргэн, аж ахуйн нэгжид 273,6 сая төгрөгийн торгууль ногдуулж барагдуулсан. | |
| 5.1.2 | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулж, зөрчлийг арилгуулна. | - | Зөрчил арилгуулалтын хувь | 89 | 91,6 | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00- хамрагдсан. Шалгалтын явцад нийт 251 зөрчил илрүүлж 30 буюу 11.9 хувийг арилгуулсан. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 247 заалт бүхий 50 албан шаардлага, 44 зөвлөмжийг хүргүүлж, 13 аж ахуйн нэгж, иргэнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, хялбаршуулсан журмаар 7, зөрчлийн хэрэг 6 нээж, нийт 13,600,000 (арван гурван сая зургаан зуун мянган) төгрөгийн шийтгэл ногдуулан, 7 албан даалгавар хүргүүлж, 2 аж ахуйн нэгжийн 15 нэр төрлийн 109 ширхэг 3516 кг, 21,840,060 (хорин нэгэн сая найман зуун дөчин мянга жаран) төгрөгийн хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх зөвлөлд шилжүүлж, эрсдэлээс урьдчилан | 100 |

| *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв сая.төг* | *Шалгуур үзүүлэлт* | *Суурь түвшин* | *Зорилтот түвшин* | *Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/* | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
